Эрдэс баялгаас
эрдэм мэдлэг, ур чадвар,
үнэт зүйлс бүтээлцэнэ

Оюу Толгой

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны IV улирлын тойм мэдээ

OTMongolia · OTMongolia · Oyu Tolgoi · OTMongolia · OTMongolia

## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.

2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар
25,202,135
Хүн/цаг

Гүйцэтгэл
0.14

2021 онд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.14 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.

Ноцтой эрсдэлийн удирдлага
117,076
Магадлагаа

Амь нас хамгаалах зорилготой "Ноцтой эрсдэлийн удирдлага" хөтөлбөрийн хүрээнд 117,076 магадлагаа хийлээ.

## МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

96.5%

Нийт ажиллах хүчний 96.5 хувийг монгол иргэд бүрдүүлж байна. Үүнээс 20.3 хувь нь говийн уурхайн төслийн ажилтнууд юм.

## УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)




## УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)




1.2м³

Оюу Толгой 0.4м³

**Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.**

## УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2021/IV улирал)

126
тэрбум төгрөг

88.29%

2021 онд зорилтоо давуулан биелүүлж ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 88.29 хувьд хүргэв.

## БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)

220,191

Нийт 220,191 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.

**БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР**
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш **3,603** оюутан,

**ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**
2013 оноос хойш ахлах ангийн **1,210** сурагч,

**"ГОВИЙН ОЮУ" САН, МАЛЧИН ӨРХИЙН ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ**
2010 оноос хойш Өмнөговийн **432** оюутан тус тус хамрагджээ.

## ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2021/IV улирал, сая ам.доллар)

ӨСӨН НЭМЭГДСЭН ДҮНГЭЭР **4.1** ТЭРБУМ АМ.ДОЛЛАР




2021 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 864 харилцагчтай хамтран ажилласны 540 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 71 хувийг зарцуулав. 2010 оноос хойш үндэсний худалдан авалтад 4.1 тэрбум ам.доллар зарцуулсан. 2021 онд нийт худалдан авалт 606 сая ам.долларт хүрсэн нь хамгийн их худалдан авалт хийсэн түүхэн жил боллоо.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны IV улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

## ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2021/IV улирал, сая ам.доллар)




2010 оноос хойш өсөн нэмэгдсэн дүнгээр

**3.6**

**ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ** татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

2010 - 2021 онд татвар, хураамж, үндэсний компаниуд төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 3.6 тэрбум ам.долларыг төлсөн. 2021 онд татвар, хураамж бусад төлбөрт 681 сая ам.доллар төлжээ.

** "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.*

*** Энэ дүнд олон улсын арбитрт хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.*

## ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2010 - 2021/IV улирал, тэрбум ам.доллар)

2010 оноос хойш үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 13.4 тэрбум ам.доллар зарцуулаа.




## ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(сая ам.доллар)




2021 онд тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 6.9 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2021/IV улирал, сая ам.доллар)




2021 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 94 ханган нийлүүлэгч 216 сая.ам долларын бараа, үйлчилгээ хүргэж, хамгийн их худалдан авалт хийсэн түүхэн жил боллоо. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 888 сая ам.долларын бараа, үйлчилгээ авчээ.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ

(мян.тонн)




2021 оны дөрөвдүгээр улирал 38,894 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 2021 онд 150,000 – 180,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх төлөвлөгөөндөө хүрч 163,010 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэлээ.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(мян.унц)




2021 оны дөрөвдүгээр улирал 78,582 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. 2021 онд 400,000 – 480,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөндөө хүрч 468,090 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв.

## ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)




2021 оны дөрөвдүгээр улирал гүний уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл 3435.7 метр, харин налуу амны малталтын ажил 690.1 метрийн ахицтай байлаа.

Оюу Толгой